



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/004/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.Open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 167

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВШРҮҮЛЭХ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Т.НАРАНБУЯН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Төвшрүүлэх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 3,065,373.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,224,022.7 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 841,350.4 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2025 онд аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 15 үндсэн зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг

даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 68 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,019,047.30	1,304,529.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	641,402.98	979,076.91
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	641,402.98	979,076.91
31210	Төгрөг	641,402.98	979,076.91
33	АВЛАГА	265,126.52	182,702.17
35	БАРАА МАТЕРИАЛ	75,661.80	105,894.48
36	НӨӨЦИЙН БАРАА	36,856.00	36,856.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,549,608.89	7,129,299.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,549,608.89	7,129,299.26
39200	Биет хөрөнгө	7,523,248.89	7,103,709.26
39300	Биет бус хөрөнгө	26,360.00	25,590.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,568,656.19	8,433,828.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	401.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	401.20
41300	Өглөг	-	401.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,568,656.19	8,433,427.62
51	Засгийн газрын хувь оролцоо	8,568,656.19	8,433,427.62
51100	Засгийн газрын оруулсан капитал	656,071.52	656,071.52
51200	Хуримтлагдсан үр дүн	7,784,224.73	7,648,996.17
51210	Өмнөх үеийн үр дүн	7,302,344.22	7,773,586.73
51220	Тайлант үеийн үр дүн	481,880.51	(124,590.56)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,568,656.19	8,433,828.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,665,739.30	4,760,977.41
11	ТАТВАРЫН ОРЛОГО	533,684.32	538,316.91
110	Орлогын албан татвар	480,023.12	436,098.51
1100	Хувь хүний орлогын албан татвар	479,983.52	470,857.43
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	39.60	23.76
113	Хөрөнгийн албан татвар	19,294.47	60,539.54
118	Бусад татвар, төлбөр, хураамж	34,366.73	41,678.86
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,338.26	8,629.88
1181	Газрын төлбөр	16,757.74	24,029.36
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,270.73	9,019.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	933,315.76	4,222,660.50
120	Нийтлэг татварын бус орлого	933,315.76	507,483.98
122	Тусламжийн орлого	-	2,801,947.65
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,801,947.65
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	913,228.86
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,337,981.69	4,156,458.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,337,981.69	4,156,458.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,970,623.72	2,281,603.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686,637.39	824,123.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,987.02	103,817.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	246,608.80	292,638.83
2104	Хангамж, бараа материалын зардал	59,057.16	46,644.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,162.60	92,549.35
2107	Томилолт, зочны зардал	2,417.20	8,110.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,712.03	19,762.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	825,041.52	893,957.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,367,357.97	1,874,854.35
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,836,406.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,214.00	38,447.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,327,757.61	604,519.22
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	845,877.10	729,109.79
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(845,877.10)	(729,109.79)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	481,880.51	(124,590.56)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,914,025.58	4,409,040.01
11	ТАТВАРЫН ОРЛОГО	533,684.32	538,316.91
110	Орлогын албан татвар	480,023.12	436,098.51
1100	Хувь хүний орлогын албан татвар	479,983.52	470,857.43
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(34,782.68)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	39.60	23.76
113	Хөрөнгийн албан татвар	19,294.47	60,539.54
118	Бусад татвар, төлбөр, хураамж	34,366.73	41,678.86
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,338.26	8,629.88
1181	Газрын төлбөр	16,757.74	24,029.36
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,270.73	9,019.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	181,602.05	3,870,723.10
120	Нийтлэг татварын бус орлого	181,602.05	278,752.79
122	Тусламжийн орлого	-	2,678,741.45
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,678,741.45
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	913,228.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,198,739.22	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,517.85	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,143,221.37	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,576,864.40	3,339,256.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,576,864.40	3,339,256.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,209,506.43	1,464,401.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686,637.39	823,722.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,987.02	103,817.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,985.00	303,828.43
2104	Хангамж, бараа материалын зардал	28,522.73	44,928.60
2105	Норматив зардал	800.00	3,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,623.00	103,241.85
2107	Томилолт, зочны зардал	2,417.20	5,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,625.35	22,100.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,908.75	54,252.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,367,357.97	1,874,854.35
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,836,406.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,214.00	38,447.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,326,143.97	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,337,161.19	1,069,783.72
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	848,993.40	732,109.79
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	848,993.40	732,109.79
2200	Дотоод эх үүсвэрээр	848,993.40	732,109.79
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	488,167.79	337,673.93
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	153,235.19	641,402.98
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	641,402.98	979,076.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,086,775.68	8,086,775.68
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,086,775.68	8,086,775.68
3	Тайлант үеийн үр дүн	481,880.51	481,880.51
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,568,656.19	8,568,656.19
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,568,656.19	8,568,656.19
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(10,638.00)	(10,638.00)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,558,018.19	8,558,018.19
8	Тайлант үеийн үр дүн	(124,590.56)	(124,590.56)
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,433,427.62	8,433,427.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	843,295.70	693,863.49	- 149,432.21	82.28
11	Татварын орлого	542,375.70	538,316.91	- 4,058.79	99.25
110	Орлогын албан татвар	397,999.80	436,098.51	38,098.71	109.57
1100	Хувь хүний орлогын албан татвар	434,480.00	470,857.43	36,377.43	108.37
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 36,500.00	- 34,782.68	1,717.32	95.30
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	19.80	23.76	3.96	120.00
113	Хөрөнгийн албан татвар	106,806.00	60,539.54	- 46,266.46	56.68
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37,569.90	41,678.86	4,108.96	110.94
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,506.00	8,629.88	- 1,876.12	82.14
1181	Газрын төлбөр	18,238.40	24,029.36	5,790.96	131.75
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	8,825.50	9,019.62	194.12	102.20
12	Татварын бус орлого	300,920.00	155,546.59	- 145,373.41	51.69
120	Нийтлэг татварын бус орлого	300,920.00	155,546.59	- 145,373.41	51.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,144.90	823,722.66	- 23,422.24	97.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,039.60	103,817.92	- 2,221.68	97.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	338,644.20	303,828.43	- 34,815.77	89.72
2104	Хангамж, бараа материалын зардал	60,914.60	44,088.60	- 16,826.00	72.38
2105	Норматив зардал	3,000.00	3,000.00	-	100.00
2107	Томиллолт, зочны зардал	8,000.00	5,510.00	- 2,490.00	68.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,716.30	17,564.04	- 10,152.26	63.37

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,365.90	54,252.43	- 63,113.47	46.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,831.70	1,519,013.19	1,475,181.49	3,465.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,480,565.59	1,480,565.59	#DIV/0!
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,831.70	38,447.60	- 5,384.10	87.72
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,194,419.90	729,109.79	- 465,310.11	61.04
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	211,646.00	-	- 211,646.00	-
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	- 278,070.60	214,467.73	(492,538.33)	- 77.13
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	278,070.60	- 214,467.73	(492,538.33)	- 77.13
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	278,070.60	214,467.73	(492,538.33)	- 77.13
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	641,402.98	641,402.98	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	979,076.91	979,076.91	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,376.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,376.01
122	Тусламжийн орлого	8,376.01
1221	Хандив тусламж /дотоод/	8,376.01
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,376.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,376.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,376.01
2104	Хангамж, бараа материалын зардал	840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,536.01

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй 16,844.5 мянган төгрөгийн зөрчил илэрч 300.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 16,544.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 16,844.5 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн бөгөөд батлагдсан төсвийн дүнгээс 1.5 хувиар буюу 45,980.6 мянган төгрөгөөр тооцсон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Төвшрүүлэх сумын 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 15,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Үлийн цагаан оготно устгах ажлын гүйцэтгэгч ЕБЛА" ХХК-д захиалагчийн хяналтын зардал болох 300.0 мянган төгрөгийн илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн Сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн

282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.6-д "...захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардлыг тус тусын дансанд холбогдох баримт, материал, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх ..." гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгч "ЕБЛА" ХХК-аас илүү тооцож шилжүүлсэн 300.0 мянган төгрөгийг гаргуулан аймгийн орон нутгийн төсвийн орлогын 10010000955 дансанд буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Төвшрүүлэх сумын 2025 оны орон нутгийн төсвийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 2,459.000 төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.

.Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2.2. Төвшрүүлэх сумын Хоршоо хөгжүүлэх санд 2025 оны жилийн эцсийн байдлаар 8 зээлдэгчтэй холбоотой 14,085.472 төгрөгийн чанаргүй буюу 9-15 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ", 10 дугаар зүйлийн 10.1-т "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина", 11 зүйлийн 11.3-т "Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлдэгч нарын зээлийг эргэн төлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2.3. Төвшрүүлэх сумын 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх баталсан 65,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй сумын Эрүүл мэндийн төвийн бохирын байгууламж суурилуулах ажил, 200,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Бор бургастын рашаанд ариун цэврийн байгууламж барих ажил, 500,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нэгдсэн хогийн цэгийг стандарт болгох ажил, 132,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн эзэмшлийн зам талбай барилга байгууламжийн урсгал засварын тохижилтын ажлын худалдан ажиллагааг 2025 оны 06 дугаар сараас 08 дугаар сарын хооронд зохион байгуулж сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар 13.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална", 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгчид шилжүүлсэн	1	300.0	1	300.0		
Хог хаягдлын хураамжийн орлого 2,459.0 мянган төгрөгөөр тасарсан	1	2,459.0			1	2,459.0
8 зээлдэгчтэй холбоотой 14,085.472 төгрөгийн чанаргүй буюу 9-15 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.	1	14,085.5			1	14,085.5
ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 4 ТАХ-ний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй.	1	0.0			1	
Нийт дүн	4	16,844.5	1	300.0	3	16,544.5